



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 06 сарын 04 өдөр

Дугаар А/434

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны 56 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх, шинэ технологи, инновац шингээсэн гарааны бизнес эрхлэгч залуучуудад гарааны санхүүжилт олгох “Стартап” арга хэмжээнд оролцож шалгарсан төслүүдэд 20,000,000 төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй гарааны бизнес эрхлэгч залуучуудад санхүүжилт олгох “Хамгийн сайн халамж-Хөдөлмөр эрхлэлт” арга хэмжээнд оролцож шалгарсан төслүүдэд 10,000,000 төгрөгийн дэмжлэг олгосугай.

2. Дээрх зардалд зарцуулах 30,000,000 (гучин сая) төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2025 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний 5.6-д тусгагдсан Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын төсөл арга хэмжээний зардлаас тооцож гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Г.Батсайхан), Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Анхбаяр) нарт зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Баярт)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

М.АМАРСАНАА



8400001 1293

Zah A/434 Kb